



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус Нийгмийн даатгалын ерөнхий газар, 9 дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,886,934,146.9 (нэг тэрбум найман зуун наян зургаан сая есөн зуун гучин дөрвөн мянга нэг зуун дөчин зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 9 дүүргийн нийгмийн даатгалын газарт төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, 9 дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга нарт төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон дотоод хяналтыг сайжруулах, тайлан дахь зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тус тус үүрэг болгосугай.

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3.Төрийн өмчийн эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой тогтоол шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байх;

2.4.Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6-д заасны дагуу суудлын автомашины тоо, төрлийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар тогтоолгох;

2.5.Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.6.Нийгмийн даатгалын ерөнхий газрын баланст бүртгэлтэй цахим архивын барилгын 2, 6, 7, 10, 11 дүгээр давхрын хэсгийн ашиглалттай холбоотой асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч шийдвэрлэх;

2.7.Нийгмийн даатгалын ерөнхий газрын салбар нэгжүүдийн барилга, инженерийн байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгө, мод, бут сөөг зэргийг хууль, стандартын дагуу бүртгэх;

2.8.Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглах боломжтой хөрөнгийн цаашид ашиглах жил, өртгийг шинэчлэн тогтоох, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг зохих журамд заасны дагуу акталж данснаас хасах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч шийдвэрлэж байх;

2.9.Багануур дүүргийн автограф, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын төв барилга, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн тасгийн барилгууд чанар, аюулгүй байдал, стандарт нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж буруутай этгээдээр хохирлыг барагдуулах;

2.10.Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн (хуучин нэрээр) хуучин барилгыг цаашид ашиглах эсэхийг Налайх дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагатай зөвшилцөж холбогдох журмын дагуу түрээсийн гэрээ байгуулж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

2.11.Газар эзэмших, ашиглах эрхийн хэмжээнд өөрчлөлт орсон, шинээр олж авсан тохиолдол бүрд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч бүртгэх;

2.12.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын эзэмшил газрыг эгүүлэн авах ажлыг зохион байгуулах;

2.13.Төрийн өмчийн талбайд байршуулсан АТМ, үүрэн операторын антен, бусад тоног төхөөрөмж, илүүдэлтэй байр, талбайн түрээстэй холбоотой асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч, түрээсийн гэрээ байгуулж ажиллах;

2.14.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.2 -д заасны дагуу хөрөнгийн дансны ангиллыг шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч бүртгэх;

2.15.Төрийн өмчийн хорооны 2013 оны “Үл хөдлөх хөрөнгө актлах зөвшөөрөл олгох тухай” 466 дугаар тогтоолоор актлагдсан, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг нураах зардлыг 2026 оны төсөвт тусгуулах арга хэмжээг зохих журмын дагуу авч ажиллах;

2.16.Барилга байгууламжид хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогийн талаарх мэдээлэл, үндсэн үзүүлэлтийг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг

хөтлөх журам"-д заасны дагуу барилга, байгууламжийн хувийн хэргийг тогтмол хөтлөх, хяналт тавьж ажиллах;

2.17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дугаарт заасны дагуу төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулж, тооллогын мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байх;

2.18.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж, төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих ажлыг дотоод хяналтын хорооны тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган, мөрдөж ажиллах;

2.19.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11 дэх хэсэгт заасны дагуу Сангийн яамнаас мэдээлсэн нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ ашиглах;

2.20.Төрийн өмчид эд хөрөнгө худалдан авах үйл ажиллагаандаа Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах.

3.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хяналт тавьж ажиллах албан үүргээ хангалтгүй биелүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтан нарт тус тус "Төрийн албаны тухай хууль" болон бусад холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцох.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
11 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Нийгмийн даатгалын ерөнхий газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	2023 онд Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороонд байршилтай, аж ахуйн зориулалт бүхий 7048 м.кв газрын хэмжээнд орсон хасагдах өөрчлөлт бүртгэгдээгүй	16,132,710	“Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн дагуу залруулан бүртгүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэн шийдвэрлүүлэх
2	Өөр төсвийн шууд захирагчийн урсгал төсвөөс бэлтгүүлсэн 6 ширхэг техник хэрэгслийг НДЕГ-ын дарга 2024.10.02-ны өдрийн А/167 тоот тушаалаар салбаруудад хуваарилж бүртгүүлсэн.	13,030,500	“Төсвийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, журамд нийцүүлж зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах
3	Өөрийн талбайг тусгасан ашиглаагүй эзэмшлийн баланстаа боловч	1,815,051,755.5	“Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн дагуу “Цахим архивын барилга”-аас өөрт ногдох хэсгийг гэрээгээр баталгаажуулах, эзэнтэй болгох, ашиглагч байгууллагуудын ашиглаж байгаа байр талбайн хэмжилт баталгаажуулалтыг хийж төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах
4	27,450,000 төгрөгийн Сонато УБҮ-08-68 дугаартай тээврийн хэрэгслийн өмчлөгчийн нэрийг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй	-	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаж шийдвэрлүүлэх

5	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлээгүй	-	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль Мэдээллийн технологийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэх
6	Ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоосон 6 ширхэг зөөврийн компьютерын өөрчлөлтийг данс бүртгэлд тусгаагүй	8,554,741.40	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 11 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах
7	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газарт шилжүүлэхээр зөвшөөрөл олгосон 1 ширхэг иж бүрэн Dell, Optiplex 3020 компьютерыг шилжүүлж, данснаас хасаагүй	2,452,120.00	ТӨБЗГ-ын 2025.01.09-ний өдрийн 11 дүгээр тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах
НИЙТ ДҮН:		1,855,221,826.9	(Нэг тэрбум найман зуун тавин таван сая хоёр зуун хорин нэгэн мянга найман зуун хорин зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөг

--oOo--



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
24/д дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 1 ширхэг компьютерыг дутуу хүлээлгэж өгсөн.	2,452,120	“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13.1 дэх заалтыг мөрдөж ажиллах
2	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8,235,000 төгрөгийн балансын үнэ бүхий Sonata-8 маркийн 8585 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		2,452,120	(хоёр сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун хорь) төгрөг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
 246... дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	2024 онд гэрээгээ нөхөн дүгнүүлэх, хариуцлага алдсан асуудлыг байгууллагын дотоод дүрэм журмын хүрээнд шийдвэрлэх.	-	“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн холбогдох заалт, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллах
2	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8,4 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 0824 УНЯ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн			-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
... дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа 2 нэр төрлийн 8 ширхэг камерыг үндсэн хөрөнгөд бүртгэх.	1,806,000	“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 14.4.5 дах заалтыг мөрдөж ажиллах
2	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12,2 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 1332 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		1,806,000	(нэг сая найман зуун зургаан мянга) төгрөг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11,7 сая төгрөгийн балансын үнэ бүхий Киa Серато маркийн 0733 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн
 зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулсан.	--	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах
2	Нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй.	-	“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах
3	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12,15 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 5516 УАВ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн			-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
42... дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөд хувийн хэвшлийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй гэрээ хэлцэлгүй ашиглуулсан.	-	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах
2	Нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй.	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Нягтлан бодох бүртгэл хөтлөх, 14.4.1 дэх хэсгийг мөрдөж ажиллах
3	Конторын барилгын дулааны худаг шугамд их засварын шинжтэй засвар үйлчилгээ хийсэн боловч капиталжуулаагүй.	10,932,200.00	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17 үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах
4	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9,9 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 9077 УНГ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		10,932,200.00	(арван сая есөн зуун гучин хоёр мянга хоёр зуу) төгрөг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
2025... дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт


Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12,71 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 0736 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн			-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
2025 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан урсгал зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бэлтгээгүй	16,522,000.00	Сангийн сайдын 2023 оны 211 тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Эдийн засгийн ангиллын тайлбар”-ыг мөрдөж ажиллах
2	Конторын болон гараашийн барилгад их засварын шинжтэй засвар үйлчилгээ хийсэн боловч капиталжуулаагүй.	-	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17 үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах
3	Нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй.	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Нягтлан бодох бүртгэл хөтлөх, 14.4.1 дэх хэсгийг мөрдөж ажиллах
4	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9,9 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 0416 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		16,522,000.00	(арван зургаан сая таван зуун хорин хоёр мянга) төгрөг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01 –ний өдрийн
24 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт



Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Чингэлтэй дүүргийн 13-р хороо, Хайлаастанд байрлах конторын зориулалттай барилгын доорх 460 м2 талбай бүхий газар эзэмшүүлэх эрхийн хугацааг сунгуулаагүй.	460 м2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолыг үндэслэн шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах
2	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9,9 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хьюндай Элентра маркийн 1989 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслийн тоо төрлийг тогтоолгоогүй.	-	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		460 м2 эзэмших/ашиглах эрхийн газар	